ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Бигэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2023/03/-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Алтай хот

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Цэвэлмаа

Утас: 70484030 Цахим хаяг: tsevelmaab@audit.gov.mn

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.08.24 № 136

танай _____ -ны № _____ -т

БИГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГА
Г.МӨНХБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Бигэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Бигэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Соёлын төвийн санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж байгаатай холбоотойгоор тус хуульд заасан хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалт, хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

0702000320

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Х.ТҮВШИНБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

мянган төгрөгөөр

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,069,058.40	689,155.10
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,212,786.10	2,569,516.20
	Нийт хөрөнгийн дүн	**7,281,844.50**	**3,258,671.30**
	Нийт өр төлбөрийн дүн	9,503.00	12,553.00
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	7,272,341.60	3,246,118.30
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	**7,281,844.60**	**3,258,671.30**
	Үйл ажиллагааны орлогын дүн	4,388,918.60	2,181,338.60
	Үйл ажиллагааны зардлын дүн	3,418,466.60	827,726.70
	Үйл ажиллагааны үр дүн	**970,452.00**	**1,353,611.90**
	Үйл ажиллагааны бус үр дүн	450,289.0	5,155,120.8
	Үйл ажиллагааны нийт үр дүн	520,163.00	-3,801,508.90
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,853,864.20	7,272,341.60
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,089,728.80	-224,714.40
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-191,414.50	
	Тайлант оны үр дүн	520,163.10	-3,801,508.90
	Эцсийн үлдэгдэл	**7,272,341.60**	**3,246,118.30**
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,689,873.2	1,030,974.6
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,361,004.1	701,912.8
	Үйл ажиллагааны ЦМГ	**328,869.10**	**329,061.80**
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-195,261.30	-326,662.10
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0	-123,000.00
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	133,607.80	-120,600.30
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	284,224.5	417,832.3
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	417,832.3	297,232.1
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	**2,580,279.20**	**1,213,823.70**
	Урсгал зардал	2,254,925.90	659,878.20
	Хөрөнгийн зардал	218,097.50	391,116.30
	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	107,255.80	162,829.20
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	**2,580,279.20**	**1,213,823.70**
	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,676,335.50	
	Орон нутгийн төсвөөс	553,418.80	724,488.80
	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	142,743.00	273,877.10
	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс	12,206.60	
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	195,575.30	215,457.80

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 50.6 сая төгрөгийн зөрчил[1] илэрснээс, 50.6 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.1 Албан шаардлага

Орон нутгийн орлогын төлөвлөгөөг үзэхэд хөрөнгийн орлогыг 11.6 сая төгрөгөөр, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг 1.4 сая төгрөгөөр, бууны албан татварыг 0.8 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийг 0.4 сая төгрөгөөр, газрын төлбөрийг 36.3 сая төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-т "Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Бигэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 54 дүгээр тогтоолыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бигэр сумын Засаг даргын Тамгын газар	1	65.4			1	65.4	1	65.4				
Бигэр сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	43.2			1	43.2	1	43.2				
Дүн	**2**	**109**	**-**	**-**	**2**	**109**	**2**	**109**				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бигэр сумын Засаг даргын Тамгын газар	12	48.9	5	8.8	5	40.1	1		1	1		
Бигэр сумын ИТХ	1	1.3	1	1.3								
Бигэр сумын Хоршоо хөгжүүлэх сан	2	15.3	1	12.8	1	2.5						
Бигэр сумын ОНХС	2	70.0	1	1.5	1	68.5						
Дүн	**17**	**135.5**	**8**	**24.4**	**7**	**111.1**	**1**	**-**	**1**	**1**		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой зөрчил								
Бигэр сумын Засаг даргын Тамгын газар	1	-	-	-	-	-	1	-
Бигэр сумын ТТЗ	1	50.6			1	50.6	1	
Дүн	**2**	**50.6**	**0**	**0**	**1**	**50.6**	**2**	**-**

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр						
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Бигэр сумын ТТЗ	1	1	-	-	1	-	-	-
2	Бигэр сумын ЗДТГ	1	1				1		
3	Бигэр сумын ИТХ	1		1					
4	Бигэр сумын Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Бигэр сумын ОНХС	1		1					
6	Бигэр сумын БХНСС	1		1					
	НИЙТ	**6**		**4**		**1**	**1**	**-**	**-**